



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

**"Буянт-Ухаа" Олон улсын нисэх
буудлын үйл ажиллагааны журамд
өөрчлөлт оруулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/26 дугаар тушаал, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.2, 5.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/166 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны журмын 5.1. дэх хэсгийн "... дэд дарга орлон гүйцэтгэнэ." гэснийг "... ИНЕГ-ын даргын тушаалаар түр орлон гүйцэтгүүлнэ." гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН